ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ
(2023.12.11- 2024.05.31)

2024 оны 06 дугаар сарын 10 Өлгий хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог сайжруулна.** (Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2.7.3), (Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.7.3), (Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.3.9), (Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө 2.5.2, 2.7.5), (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 3, 4, 5, 6 дугаар зорилт) | | | | | | | |
| Зорилт 1. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт<br>Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, хяналтыг зохион байгуулна. | | | | | | | |
| 1 | Гадаадын иргэнд олгох Монгол Улсын виз, визийн болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн үйлчилгээг зохион байгуулах | Гадаадын иргэнд Монгол Улсын виз олгосон, визийн болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн хүсэлт шийдвэрлүүлсэн хувь | 100 | 50 | 100 | Цагааннуур боомтод нийт 4 орны 7 гадаадын иргэнд төвөөс олгосон визийн зөвшөөрлийг үндэслэн виз олгосон. Үүнд:<br>- “[illegible]” ХХК-ийн урилгаар ОХУ-ын 3 иргэнд С6 ангиллын нэг удаагийн орох виз,<br>- БНКазахстан Улсын 1 иргэнд Н3 ангиллын нэг удаагийн орох виз,<br>- БНКазахстан Улсын 1 иргэнд F1 ангиллын нэг удаагийн орох виз,<br>- БНУзбекистан Улсын 1 иргэнд С6 ангиллын нэг удаагийн орох виз,<br>- БНФранц Улсын 1 иргэнд С11 ангиллын нэг удаагийн орох виз тус тус олгосон.<br>Визийн зөвшөөрлийн хүсэлт илгээсэн 8. Үүнд:<br>- БНХАУ-ын 5 иргэний К2 ангиллын,<br>- Бүгд Найрамдах Казахстан Улсын 3 иргэний F2-1 ангиллын визийн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - зөвшөөрөл хүссэн хүсэлтийг төвд цахимаар хүргүүлсэн.<br>Визийн сунгалт хийсэн тэмдэглэл 1. Үүнд:<br>- Төвөөс визийн байх хугацааг сунгасан БНХАУ-ын 1 иргэний паспорт бичиг баримтад "бүртгэв, хүртэл" тэмдэглэгээ хийсэн.<br>Оршин суух зөвшөөрлийн чиглэлээр:<br>- Оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргасан БНКазахстан Улсын 17 иргэн,<br>- Оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан 2 орны 62 /БНКазахстан Улс-58, ОХУ-4/,<br>- Паспортын мэдээлэл өөрчлөх хүсэлт гаргасан харьяалалгүй 3 хүн,<br>- Оршин суух хэлбэр өөрчлөх хүсэлт гаргасан харьяалалгүй 3 хүний өргөдөл материалын бүрдлийг хангуулан хянаж, цахимаар төвд хүргүүлсэн.<br>Оршин суух үнэмлэх ирсэн 64 гадаадын иргэний үнэмлэхийг бүртгэлээр хүлээлгэн өгч, хувийн хэрэгт нь баяжилт хийсэн. Үүнд: БНКазахстан Улсын 49, ОХУ-ын 5, БНАзербайжан Улсын 1, Фижийн Арлуудын БНУ-ын 5 иргэн, харьяалалгүй 4 хүн.<br>Гадаадын иргэний өргөдөл болон уригчийн хүсэлтийг үндэслэн 1 орны 11 гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хасалт хийсэн. Үүнд:<br>- Эх орондоо буцах хүсэлт гаргасан БНКазахстан Улсын 7,<br>- Нас барсан БНКазахстан Улсын 2 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэн,<br>Хоёрдмол харьяалалтай байсан БНКазахстан Улсын 2 иргэн БНКазахстан Улсын харьяатаас гарсан тул оршин суух зөвшөөрлийн хасалт хийсэн. | |
| 2 | Гадаадын иргэний бүртгэл, хяналтыг эрхлэх | Гадаадын иргэний бүртгэл хийж, бүртгэлд хяналт тавьсан хувь | 100 | 50 | 100 | Тайлант хугацаанд нийт 3 орны 22 гадаадын иргэнийг бүртгэж, хассан. Үүнд:<br>- Эх орондоо буцсан ОХУ-ын 2 иргэн,<br>- Зөрчил шийдвэрлүүлсэн БНУзбекистан Улсын 10 иргэн, БНКазахстан Улсын 6 иргэн, ОХУ-ын 3 иргэн.<br>- Нас барсан БНКазахстан Улсын 1 иргэнийг тус тус бүртгэж хассан.<br>Монгол Улсаас албадан гаргах БНУзбекистан Улсын 5 иргэн, БНКазахстан Улсын 2 иргэний гарын хурууны хээ, зургийг авч дотоод сүлжээгээр төвд хүргүүлсэн. | |
| 3 | Гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр иргэдийг зөвлөгөө мэдээллээр хангах | Зөвлөгөө мэдээллийн хэлбэр, иргэнд үйлчилгээ хүргэсэн тоо | 3/2349 | 3/1150 | 3/2300 | Нийт 381 иргэн, үйлчлүүлэгчид байгууллагын цахим үйлчилгээний талаар, гадаадын иргэний цахим бүртгэл болон бусад асуудлаар зөвлөгөө мэдээлэл суурин утас болон биечлэн өгч ажилласан. ЗГХЭГ, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас цахим шилжилтийг үндэсний хэмжээнд эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн ХДТ-т зохион байгуулсан "D1" нээлттэй хаалганы өдөрлөгт хяналтын улсын байцаагч С.Алтаннурын хамт оролцож, байгууллагын цахим үйлчилгээний талаар 2 орны 16 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.<br>Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газраас Цагааннуур боомтын 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан нээлттэй | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаалганы өдөрлөг хяналтын улсын байцаагч С.Гүлбану, бичиг хэргийн эрхлэгч-нярав Н.Уганзаяа нар оролцож, 2 орны 5 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. | |
| 4 | Монгол Улсын иргэний харьяаллын талаарх хүсэлтийг хүлээн авч, холбогдох ажиллагааг зохион байгуулах | Зохион байгуулалтын ажлын хувь | 100 | 50 | 100 | Монгол Улсын харьяатаас гарах хүсэлтэй [illegible] эрхийн [illegible] иргэний өргөдөл материалын бүрдлийг хянаж, аймгийн Засаг даргаар уламжлуулан ГИХГ-т хүргүүлсэн.<br>Монгол Улсын иргэний харьяалал сэргээн тогтоолгох хүсэлтэй [illegible] эрхийн [illegible] хүн, Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан [illegible] эрхийн [illegible] хүний өргөдөл материалын бүрдлийг хянаж, Иргэний харьяаллын газарт хүргүүлсэн.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн [illegible] өдрийн [illegible] дугаар зарлигын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. /[illegible] иргэн харьяатаас гарах тухай/<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн [illegible] өдрийн [illegible] дугаар зарлигын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. /[illegible] иргэн харьяатаас гарах тухай/<br>Иргэдээс гаргасан өргөдөл, хүсэлтийн дагуу иргэний харьяаллын чиглэлээр нийт 28 лавлагаа олгож ажилласан. | |
| 5 | Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийн бүртгэл, судалгаа | Зохион байгуулалтын | 100 | 50 | 100 | Тайлант хугацаанд Монгол Улсын харьяатаас гарахгүй | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтлөх, зөрчлийг шийдвэрлэх арга хэмжээ зохион байгуулах | ажлын хувь | | | | БНКаз.Улсын харьяат болж, хоёрдмол харьяалал үүсгэсэн нийт [redacted] зөрчлийг илрүүлж, бүртгэлжүүлсэн.<br>Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийн бүртгэлээс хасалт хийсэн: [redacted]. Үүнд:<br>- Хоёрдмол харьяалалтай байсан БНКазахстан Улсын [redacted] иргэн БНКазахстан Улсын харьяатаас гарсан тул оршин суух зөвшөөрлийн хасалт хийсэн.<br>[redacted]<br>Цаасан болон цахим хэлбэрээр бүртгэл хөтөлж, баяжуулсан.<br>Хоёрдмол харьяаллын чиглэлээр 2024 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. | |
| 6 | Харьяалах нутаг дэвсгэрт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчлийг шийдвэрлэх | Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн болон зөрчил шалган шийдвэрлэх хувь | 100 | 50 | 100 | Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалт 2 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 1 удаа хийсэн. Үүнд:<br>Хэлтсийн даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах [redacted] ХХК (автомашин засварын газар)-д төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар тус компанид хөдөлмөр эрхэлж байсан Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын иргэн [redacted] нь биедээ баримт бичиггүй, хэн болох нь тогтоогдохгүй, хууль ёсны уригч байгууллагын нэр дээр хөдөлмөр эрхлээгүй, оршин суух зөвшөөрлийн хугацааг хэтрүүлсэн байж болзошгүй | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зэрэг нөхцөл байдал илэрсэн талаар хэлтсийн даргад илтгэх хуудсаар танилцуулж, тус аж ахуйн нэгж, байгууллагад албан шаардлага хүргүүлсэн.<br>Хэлтсийн даргын баталсан БӨ-2024/17-02 тоот удирдамжийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 03 дугаар сарын 20-ны өдрүүдэд уул уурхай, хүмүүнлэгийн үйл ажиллагаа, боловсролын салбарт хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийн паспорт, баримт бичиг, оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт, оршин суух зөвшөөрөл нь холбогдох хууль, тогтоомжид нийцэж буй эсэх, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хяналт шалгалт явуулсан. Шалгалтад 5 аж ахуйн нэгж, байгууллагын 4 улсын 19 гадаадын иргэн хамрагдсан. Үүнд:<br>- Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын [illegible] сургуульд хөдөлмөр эрхэлж буй Швейцарь Улсын 2 иргэн,<br>- [illegible]” сургалтын төвд хөдөлмөр эрхэлж буй Бүгд Найрамдах Фижи Улсын 5 иргэн,<br>- [illegible] байгууллагад хөдөлмөр эрхэлж буй Норвеги Улсын 6 иргэн,<br>- Цэнгэл сумын 7 дугаар багт уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж буй [illegible] ХХК-д | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - хөдөлмөр эрхэлж буй БНХАУ-ын 2 иргэн,<br>Ногооннуур сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэлт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй [redacted] ХХК-д хөдөлмөр эрхэлж буй БНХАУ-ын 4 иргэн нийт шалгалтад хамрагдсан. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилгүй. Шалгалтын үр дүнгийн талаар илтгэх хуудсаар танилцуулсан.<br>Байгууллагын даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хяналт шалгалтаар ажиллах тухай 1-05/08 дугаар удирдамжийн хүрээнд Баян-Өлгий аймгийн хэмжээнд оршин сууж буй нийт 443 гадаадын иргэний судалгаа гаргаж, чиглэлийн дагуу хяналт шалгалтаар ажилласан.<br>Шалгалтад Баян-Өлгий аймгийн 12 сум, 1 тосгонд гэр бүлийн шалтгаанаар болон хувийн бусад зорилгоор оршин сууж буй 5 орны 301 гадаадын иргэн, 14 харьяалалгүй хүн, 9 аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхэлж буй 8 орны 38 гадаадын иргэн, аялал жуулчлалын зорилгоор түр зорчиж байсан БНХАУ-ын 5 иргэн нийт 8 орны 344 гадаадын иргэн, 14 харьяалалгүй хүн шалгалтад хамрагдсан.<br>Шалгалтад хамрагдсан 9 аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг обьектын судалгаанд хамруулсан.<br>Шалгалтаар илэрсэн дараах зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэж ажилласан. Үүнд:<br>- Оршин суух хугацааг хэтрүүлсэн Бүгд | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Найрамдах Казахстан Улсын 4 иргэнийг нийт 150.000 төгрөгөөр,<br>Оросын Холбооны Улсын 3 иргэнд хуульд заасан хугацаанд оршин суух зөвшөөрөл аваагүй [illegible] ХХК-ийг нийт 720.000 төгрөгөөр,<br><br>- Швейцарь Улсын 1 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг хэтрүүлсэн [illegible] ХХК-ийг 20.000 төгрөгөөр тус тус торгож зөрчлийг шийдвэрлэсэн.<br>Тайлант хугацаанд нийт 2 орны 18 гадаадын иргэн, харьяалалгүй 1 хүн, 4 аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох зөрчлийг шалгаж шийдвэрлэж, нийт 14.120.000 төгрөгийн хүү, торгуулийн орлого төвлөрүүлсэн. Үүнд:<br>- Визийн хугацаа хэтрүүлсэн Бүгд Найрамдах Казахстан Улсын 7 иргэн, Бүгд Найрамдах Узбекистан Улсын 2 иргэнийг нийт 3.950.000 төгрөгөөр,<br><br>- Оршин суух зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн Бүгд Найрамдах Казахстан Улсын 7 иргэн, харьяалалгүй 1 хүнийг нийт 6.050.000 төгрөгөөр,<br><br>Ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан Бүгд Найрамдах Узбекистан Улсын 1 иргэнийг 100.000 төгрөгөөр,<br><br>- Нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэхийг эзэмших, ашиглах, | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| --- | --- | --- | --- | --- | --- | --- | --- |
| | | | | | | - хадгалах журам зөрчсөн Бүгд Найрамдах Казахстан Улсын 1 иргэнийг 100.000 төгрөгөөр,<br>- Бүгд Найрамдах Узбекистан Улсын 1 иргэний визийн байх хугацааг хэтрүүлсэн [illegible] ХХК-ийг 330.000 төгрөгөөр,<br>- Бүгд Найрамдах Узбекстан Улсын 2 иргэнд хуульд заасан хугацаанд оршин суух зөвшөөрөл аваагүй [illegible] ХХК-ийг нийт 1.800.000 төгрөгөөр,<br>- Швейцарь Улсын 2 иргэнд хуульд заасан хугацаанд оршин суух зөвшөөрөл аваагүй [illegible] ЕБС-ийг нийт 200.000 төгрөгөөр,<br>- ОХУ-ын 3 иргэнд хуульд заасан хугацаанд оршин суух зөвшөөрөл аваагүй [illegible] ХХК-ийг нийт 870.000 төгрөгөөр,<br>- Бүгд Найрамдах Узбекистан Улсын 2 иргэнд хуульд заасан хугацаанд оршин суух зөвшөөрөл аваагүй [illegible] ХХК-ийг нийт 720,000 төгрөгөөр тус тус торгож, зөрчлийг шийдвэрлэсэн.<br>Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-т заасныг тус тус үндэслэн [illegible] ХХК, “[illegible]” ХХК, [illegible]” ХХК-д нийт 3 албан шаардлага хүргүүлсэн. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Харьяалах нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт хяналт тавих | Хяналт тавьсан ажлын гүйцэтгэл | 100 | 50 | 100 | Тус аймагт үйл ажиллагаа явуулдаг [illegible]ын үйл ажиллагаанд 2024 оны 3, 5 дугаар сард төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2 удаа хийж, гадаадын иргэдийн бичиг баримт, оршин суух үнэмлэхийн хугацаа, зөвшөөрөлтэй хөдөлмөр эрхэлж байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан.<br>Тус байгууллага, гадаадын иргэний бичиг баримттай холбоотой зөрчил илрээгүй. | |
| 8 | Гадаадын иргэний хяналтыг сайжруулж, хууль зөрчсөн иргэнд хориг арга хэмжээ авч хэрэгжүүлэх | Хууль зөрчсөн гадаадын иргэнд авсан хориг арга хэмжээний хувь | 100 | 50 | 100 | Тайлант хугацаанд нийт 2 орны 8 гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах дүгнэлт үйлдэж, байгууллагын даргын шийдвэрээр Цагааннуур боомтоор Монгол Улсад 1-3 жилийн хугацаанд Монгол Улсад дахин орох эрхгүйгээр албадан гаргасан. Үүнд:<br>- Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн саналын дагуу Бүгд Найрамдах Казахстан Улсын 1 иргэн,<br>- Монгол Улсад визийн хугацаа хэтрүүлсэн Бүгд Найрамдах Узбекистан Улсын 2, Бүгд Найрамдах Казахстан Улсын 2 иргэн,<br>- Оршин суух зөвшөөрлийн хугацааг хэтрүүлсэн Бүгд Найрамдах Узбекистан Улсын 3 иргэн.<br>Монгол Улсаас албадан гаргаж буй гадаадын иргэдэд сонсох ажиллагааг явуулж, бүртгэж хасах болон гарын хурууны хээг авч, мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулсан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсаас албадан гаргахаас чөлөөлүүлэх тухай Бүгд Найрамдах Казахстан Улсын 2 иргэний өргөдлийг төвд уламжилсан.<br>Албадан гаргасан бөгөөд Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаа дуусаагүй Бүгд найрамдах Казахстан Улсын 2 иргэн, ОХУ-ын 1 иргэнтэй ярилцлага хийж, Цагааннуур авто замын боомтоор улсын хил нэвтрүүлэлгүй буцаасан. | |
| Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт<br>Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ. | | | | | | | |
| 9 | Байгууллагын авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний холбогдох заалтын хэрэгжилтийг хангах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 50 | 100 | Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Хэлтсийн төрийн захиргааны 4 албан хаагч 2023 оны ХАСХОМ-ээ хуулийн хугацаанд мэдүүлж, баталгааны хуудсаа төвд хүргүүлсэн,<br>- Албан тушаал дэвшин томилогдохоор нэр дэвшсэн хэлтсийн дарга [redacted], виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн [redacted], шилжин томилогдох хүсэлт гаргасан [redacted] нар ХАСУМ-ээ мэдүүлсэн,<br>- Шинээр томилогдсон мэргэжилтэн [redacted] хуулийн хугацаанд ХАСХОМ-ээ мэдүүлсэн.<br>Авлигын эрсдэлээс ангид байх чиглэлээр ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2 ширхэг зураг | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуудас, 25 ширхэг брошур бэлтгэж хэлтсийн төвд байрлуулсан. Давхар ажил эрхлэлтийн талаар судалгаа нийт албан хаагчаас авсан.<br>Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, мэдээллийн ажил зохион байгуулах арга хэмжээний хүрээнд виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Ц.Дүүриймаа хэлтсийн албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх агуулга бүхий видео бичлэг үзүүлэн сурталчилж, мэдээлэл хийсэн. | |
| 10 | Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний холбогдох заалтын хэрэгжилтийг хангах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 50 | 100 | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн.<br>Үүнд:<br>- Хэлтсийн нийт 8 албан хаагч 2024 оны 05 дугаар сарын 08-нд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан.<br>Цагааннуур авто замын боомтод амралтын өдөр илүү цагаар ажилласан 4 албан хаагчийг давхардсан тоогоор нийт 15 хоног биеэр нөхөн амраасан. Мөн хилийн боомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг албаны унаагаар хүргэж авсан.<br>- Улаанбаатар хотод албаны шугамаар томилолтоор явсан | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт 7 албан хаагчид томилолтын мөнгийг олгосон.<br>• Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системд нийт 7 удаа мэдээлэл шинэчилж оруулсан. Үүнд:<br>➢ Байгууллагын даргын 2024.04.05-ны өдрийн А/133 дугаар “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэл, цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тушаалын дагуу хэлтсийн албан хаагчдын цалингийн мэдээллийг шинэчилж оруулсан,<br>➢ Х.Төрмандахыг шилжүүлэн ажиллуулах тухай байгууллагын даргын 2024.04.15-ны өдрийн Б/92 тушаалын дагуу тус хэлтэст шинээр томилогдсон мэргэжилтэний мэдээллийг албан хаагчдын санд нэмсэн,<br>➢ Хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн төрийн үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай байгууллагын даргын 2024.04.26-ны Б/103 дугаар тушаалын дагуу хэлтсийн төрийн үйлчилгээний 4 албан хаагчийн цалингийн нэмэгдлийг оруулсан,<br>ГИХГ-ын хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тухай байгууллагын даргын 2024.04.29-ний өдрийн А/158 дугаар тушаал<br>➢ Мэргэжилтэн Х.Төрмандахын төрийн албан хаасан хугацаа нь 12 жил зөрүүтэй гэж байсныг аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хандаж, 9 жил болгож зассан.<br>➢ Засгийн газрын 2024.04.17-ны өдрийн 160 дугаар тушаал, байгууллагын даргын 2024.04.29-ний өдрийн албан хаагчдыг томилох тухай Б/105 дугаар тушаалын дагуу албан хаагчдыг шинэ бүтцэд оруулав. Байгууллагын даргын 2024.04.26-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар батлагдсан хоол, унааны нөхөх төлбөрийг шинэчлэн тогтоох тухай тушаалыг шинэчлэн оруулсан.<br>- Эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гаргаж, албан үүргээ үр дүнтэй биелүүлж амжилт гаргасан хэлтсийн дараах 3 албан хаагчийг Хууль зүй, дотоод хэргийн яамны зохих шагналуудад нэр дэвшүүлж, шагнуулсан. Үүнд:<br>➢ Хууль зүй, дотоод хэргийн яамны “Тэргүүний ажилтан”-аар хэлтсийн дарга Г.Батцэцэг,<br>➢ Хууль зүй, дотоод хэргийн яамны “Жуух бичиг”-ээр виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Ц.Дүүриймаа, хяналтын улсын байцаагч С.Алтаннур нар шагнуулсан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Байгууллагын 2024 оны сургалтын төлөвлөгөөний холбогдох заалтын хэрэгжилтийг хангах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 50 | 100 | Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөний хүрээнд хэлтсийн албан хаагчдад нийт 4 удаа сургалт зохион байгуулсан. Үүнд:<br>- Удирдлагын академиас зохион байгуулж буй Монгол бичгийн цахим сургалтад тус хэлтсийн 8 албан хаагч хамрагдаж, 1-р түвшний гэрчилгээг 8 албан хаагч, 2-р түвшний гэрчилгээг 5 албан хаагч, 3-р түвшний гэрчилгээг 3 албан хаагч авсан.<br>“Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын хор хөнөөлийн талаар” сэдвээр виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Ц.Дүүриймаа хэлтсийн албан хаагчдад танхимаар сургалт орсон.<br>- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тухай” сэдвээр хяналтын улсын байцаагч С.Гүлбану хэлтсийн албан хаагчдад танхимаар сургалт орсон.<br>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд аймгийн Онцгой байдлын газрын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, ахмад Н.Досжанаас хэлтсийн албан хаагчдад “Гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэл”, “Гамшгаас хамгаалах арга хэмжээ” сэдэвт сургалт авсан. | |
| 12 | Байгууллагын 2024 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | | 90 | 50 | 100 | Байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2024 оны | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааны төлөвлөгөөний холбогдох заалтын хэрэгжилтийг хангах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | | | | төлөвлөгөөнд тусгагдсан орон нутаг дахь нэгжтэй холбоотой 4 заалтыг хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- "Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын хор хөнөөлийн талаар" сэдвээр виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Ц.Дүүриймаа,<br>- "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тухай" сэдвээр хяналтын улсын байцаагч С.Гүлбану<br>- "Ёс зүй, харилцаа, хандлага, хувь хүний хөгжил" сэдвээр хяналтын улсын байцаагч С.Алтаннур<br>Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр хяналтын улсын байцаагч С.Гүлбану нар тус тус дотоод сургалт зохион байгуулсан. | |
| 13 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт, хариутай бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх | Шийдвэрлэлтийн хувь | 100 | 50 | 100 | Иргэн, албан хаагчдаас нийт 51 өргөдөл ирсэнээс 100 хувь шийдвэрлэгдсэн. Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас 42, албан хаагчдаас 9. Тайлант хугацаанд гомдол ирээгүй.<br>Тайлант хугацаанд нийт 65 албан бичиг ирснийг зохих журмын дагуу бүртгэж, хэлтсээс явуулсан 80 албан бичиг боловсруулан хэлтсийн даргаар хянуулан холбогдох байгууллага, иргэдэд, хариутай 16 албан бичгийн хариуг хугацаанд нь тус тус хүргүүлэн ажилласан. Дотоод албан бичиг 32 хүлээн авч, 22 хүргүүлсэн. | |
| 14 | Төсвийн шууд захирагчийн төсвийг зориулалтын дагуу зарцуулах, санхүүгийн баримтыг үнэн зөв бүрдүүлэх | Батлагдсан төсвийн дүн | 248 сая | 248 сая | 248 сая | Хэлтсийн 2024 оны төсвийг 232.110.600 төгрөгөөр батлуулж, 2024 оны эхний 5 сарын байдлаар 142.375.999 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 89.734.300 төгрөгийн хэмнэлттэй ажилласан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг шилэн дансанд тухай бүр нь байршуулан ажилласан. Санхүүтэй холбоотой бүх анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлэн ажилласан. | |
| 15 | Арга хэмжээ 2.8. Тэмдэгтийн хураамжийн орлого, хүү торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх | Төвлөрүүлсэн орлогын дүн | 65.8 сая | 20 сая | 45 сая | Тус хэлтэс 2024 оны эхний 5 сарын байдлаар хүү торгуулийн орлогын аймгийн төвлөрсөн 100020000988 дугаартай дансанд 9.680.000 төгрөгийн орлого, улсын тэмдэгтийн хураамжийн 100020000941 дугаартай дансанд 8.360.660 төгрөгийн орлого, нийт 18.040.660 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. | |
| 16 | Арга хэмжээ 2.9. Төсвийн шууд захирагчийн төсөвтэй холбоотой мэдээ, тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх | Шилэн дансанд оруулсан мэдээллийн тоо, хангасан хувь | 134/100 | 67/50 | 134/100 | Хэлтсийн улирлын санхүүгийн тайланг 1 удаа, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг 5 удаа, орлогын тайлан болон бусад тайлан мэдээг тухай бүр гаргаж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажилласан. Шилэн дансны байршуулвал зохих 68 мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн байршуулсан. | |

## ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| 1 | Арга хэмжээ 1. Монгол бичгээр албан хэрэг хөтлөх чадвар эзэмших | Сертификатын тоо | Удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулсан Монгол бичгийн цахим сургалтын 1,2 дугаар шатны сургалтад хамрагдаж сертификат авсан. | Удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулсан Монгол бичгийн цахим сургалтын 3 дугаар шатны сургалтад хамрагдаж сертификат авсан. | Мэргэжлийн багшийн заах танхимын сургалтад бие даан хамрагдана. | 2024 оны 01 дүгээр сард Хэлний бодлогын зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбарын багш С.Гаурагийн Монгол бичгийн үсгийн фонтоор компьютер дээр бичих чадвар эзэмшүүлэх, гар утасны аппликейшн ашиглах талаар сургалтад | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамрагдсан. Удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулсан Монгол бичгийн цахим сургалтын 3 дугаар шатны сургалтад хамрагдаж сертификат авсан. | |
| 2 | Арга хэмжээ 2. Англи хэлний түвшин ахиулах сургалтад бие даан хамрагдах | Сертификатын тоо | - | Эрх бүхий байгууллагаас явуулах цахим сургалтад хамрагдаж, түвшин ахиулсан байна. | Англи хэлний дүрмийн сурах бичгийг судлах, ярианы чадвараа сайжруулна. | Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 2024 оны 02 дугаар сараас эхлэн 4 сарын хугацаанд суралцаж байна.<br>Мөн БНСУ-ын КОЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагын "Гадаадын иргэн, харьяатын газрын хүртээмжтэй үйлчилгээ, менежментийн чадавхийг бэхжүүлэх нь" төслийн 2 дугаар ээлжийн 14 хоногийн хугацаатай сургалтад хамрагдаж сертификат авсан.<br>Дээрх сургалтуудад хамрагдсан тул англи хэлний түвшин ахиулах сургалтад хамрагдах хугацааг хойшлуулсан. | |

ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНЭЛСЭН: *Төсвийн төвлөрүүлэн захирагч*
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Н.УУГАНБАЯР

2024 оны 06 дугаар сарын ......

ТАЙЛАГНАСАН: *Төсвийн шууд захирагч*
ДАРГА Г.БАТЦЭЦЭГ

2024 оны 06 дугаар сарын ..10....

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ХЭЛТСИЙН ВИЗ, ЗӨВШӨӨРЛИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ЦЭРЭНДОРЖИЙН ДҮҮРИЙМААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Монгол Улсын виз, хувийн урилга хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг судлан шийдвэрлэх”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Гадаадын иргэнд олгох Монгол Улсын визийн болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн үйлчилгээг зохион байгуулах | Гадаадын иргэнд Монгол Улсын виз олгосон, визийн болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн хүсэлт шийдвэрлүүлсэн хувь | 100 | 50 | Тайлант хугацаанд нийт 2 орны 6 гадаадын иргэнд виз олгосон. Үүнд:<br>- “[illegible]” ХХК-д хөдөлмөр эрхлэх БНФранц Улсын 1 иргэнд төвөөс олгосон визийн зөвшөөрлийг үндэслэн C11 ангиллын нэг удаагийн орох виз,<br>- [illegible]” ХХК-д хөдөлмөр эрхлэх ОХУ-ын 5 иргэнд төвөөс олгосон визийн зөвшөөрлийг үндэслэн C6 ангиллын нэг удаагийн орох виз тус тус олгосон.<br>Визийн сунгалт: 1. Үүнд: БНХАУ-ын 1 иргэний визийн байх хугацааг 30 хоногоор сунгасан талаарх тэмдэглэлийг паспортод нь дарсан.<br>Оршин суух зөвшөөрлийн чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Оршин суух зөвшөөрлийн хэлбэр өөрчлөх хүсэлт гаргасан БНКазахстан | 1-6 | |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улсын 1 иргэн,<br>- Оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан Оросын Холбооны Улсын 4 иргэн, БНКазахстан Улсын 6 иргэний хүсэлтийг хүлээн авч хянан, төвд цахимаар хүргүүлсэн.<br>- Оршин суух зөвшөөрлийн хасалт хийсэн 4. Үүнд: Нас барсан БНКазахстан Улсын 2 иргэн, хоёрдмол харьяалалтай байсан БНКазахстан Улсын 2 иргэн БНКазахстан Улсын харьяатаас гарсан тул оршин суух зөвшөөрлийн хасалт хийсэн.<br>- Оршин суух үнэмлэх хүлээлгэн өгсөн: 12. Үүнд: БНКазахстан Улсын 12 иргэнд оршин суух үнэмлэхийг бүртгэлээр хүлээлгэн өгч, хувийн хэрэгт нь баяжилт хийсэн. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналтыг эрхлэх | Гадаадын иргэний бүртгэл хийж, бүртгэлд хяналт тавьсан хувь | 100 | 50 | Бүртгэл 8, хасалт 8. Үүнд:<br>- Зөрчил шалган шийдвэрлүүлсэн БНУзбекистан Улсын 3 иргэнийг бүртгэж хассан.<br>- Монгол Улсад байх визийн хугацааг хэтрүүлсэн БНКазахстан Улсын 3 иргэн 16 насанд хүрээгүй тул торгуулиас чөлөөлж, бүртгэж, хассан.<br>- Монгол Улсад визгүй 31 хоног зорчсон ОХУ-ын 2 иргэний визийн хугацаа дуусах сүүлийн өдөр нь ажлын бус өдөр таарсан тул дараагийн ажлын өдөр шилжүүлж тооцон бүртгэж хассан. | 1-6 | 100 |

56

| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Арга хэмжээ 1.3.<br>Гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр иргэдийг зөвлөгөө, мэдээллээр хангах | Зөвлөгөө, мэдээллийн хэлбэр, иргэнд үйлчилгээ хүргэсэн тоо | 721 | 340-өөс доошгүй | Тайлант хугацаанд нийт 5 орны 138 иргэн, харьяалалгүй 12 хүнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Үүнд:<br>-Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн талаар БНКазахстан Улсын 42 иргэнд, БНХАУ-ын 1 иргэн, Оросын Холбооны Улсын 2 иргэнд,<br>-Оршин суух зөвшөөрлийн паспортын мэдээлэл өөрчлөх талаар харьяалалгүй 3 хүнд,<br>-Иргэний харьяаллын лавлагаа олголтын чиглэлээр Монгол Улсын 8 иргэнд, БНКазахстан Улсын 11 иргэн, харьяалалгүй 1 хүнд,<br>-Иргэний харьяалал сэргээн тогтоолгох талаар харьяалалгүй 6 хүн, БНКазахстан Улсын 9 иргэнд,<br>-Монгол Улсын харьяат болох талаар харьяалалгүй 2 хүнд,<br>-Монгол Улсын харьяатаас гарах талаар Монгол Улсын 5 иргэнд,<br>-Визийн зөвшөөрлийн талаар ОХУ-ын 3 иргэнд, БНХАУ-ын 2 иргэнд,<br>-Визийн сунгалтын талаар БНХАУ-ын 2 иргэнд,<br>-Түр ирэгчийн бүртгэлийн талаар БНКазахстан Улсын 52 иргэн, Норвегийн Вант Улсын 1 иргэнд тус тус мэдээлэл өгч ажилласан.<br>ISF програмд БНКазахстан Улсын 12 иргэний гадаадын иргэний хаягийн бүртгэл хийсэн. | 1-6 | 80 |

Зорилт 2. “ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ГАДААДЫН ИРГЭДЭД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ, ЗӨРЧИЛ ГАРГАСАН УРИГЧ, ГАДААДЫН ИРГЭНИЙ ТАЛААР МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, ЗӨРЧЛИЙГ ХУУЛИЙН ДАГУУ ШИЙДВЭРЛЭХ”

57

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ЗГХЭГ, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас цахим шилжилтийг үндэсний хэмжээнд эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн ХДТ-т зохион байгуулсан "D1" нээлттэй хаалганы өдөрлөгт хяналтын улсын байцаагч С.Алтаннурын хамт оролцож, байгууллагын цахим үйлчилгээний талаар 2 орны 16 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. | | |
| 4. Арга хэмжээ 2.1. Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулах, зөрчлийг шалган шийдвэрлэх | Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн болон зөрчил шалган шийдвэрлэсэн хувь | 100 | 50 | Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалт 2 удаа хийгдсэн. Үүнд:<br>Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн даргын 2024 оны БӨ-2024/17-02 дугаар удирдамжийн дагуу тус хэлтсийн хяналтын улсын байцаагч Ж.Золжаргал, С.Гүлбану нарын хамт 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хооронд хяналт шалгалт хийсэн.<br>Шалгалтад 5 аж ахуйн нэгж, байгууллагын 4 улсын 19 гадаадын иргэн хамрагдсан. Үүнд:<br>- Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын "[redacted]" сургуульд хөдөлмөр эрхэлж буй Швейцарь Улсын 2 иргэн,<br>- [redacted] сургалтын төвд хөдөлмөр эрхэлж буй Бүгд Найрамдах Фижи Улсын 5 иргэн,<br>- [redacted] байгууллагад хөдөлмөр эрхэлж буй Норвеги Улсын 6 иргэн,<br>- Цэнгэл сумын 7 дугаар багт уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж буй "[redacted] ХХК-д хөдөлмөр эрхэлж буй БНХАУ-ын 2 | 1-6 | 100 |

58

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | иргэн,<br>- Ногооннуур сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэлт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "[redacted]" ХХК-д хөдөлмөр эрхэлж буй БНХАУ-ын 4 иргэн нийт шалгалтад хамрагдсан. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилгүй.<br>Байгууллагын даргын 2024.05.02-ны өдрийн хяналт шалгалтаар ажиллах тухай 1-05/08 дугаар удирдамжийн хүрээнд Баян-Өлгий аймгийн хэмжээнд оршин сууж буй нийт 443 гадаадын иргэний судалгааг гаргаж, тэдгээрийн оршин сууж буй сум, багаар нь ялгаж мэдээллийн санг бэлэн болгосон.<br>Тус удирдамжийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 08-наас 09-ний өдрүүдэд хяналтын улсын байцаагч С.Алтаннур, мэргэжилтэн Х.Төрмандах нарын хамт Баян-Өлгий аймгийн Ногооннуур суманд оршин сууж буй БНКазахстан Улсын 3 иргэн, "[redacted]" ХХК-д хөдөлмөр эрхлэгч БНХАУ-ын 4 иргэн, Цагааннуур тосгонд оршин сууж буй БНКазахстан Улсын 6 иргэн, Өлгий суманд оршин сууж буй "[redacted]" ХХК-д хөдөлмөр эрхлэгч БНУзбекистан Улсын 1 иргэн, "[redacted]" ХХК-д хөдөлмөр эрхлэгч БНСВьетнам Улсын 1 иргэн нийт 4 орны 15 гадаадын иргэнд шалгалт хийсэн.<br>Шалгалтаар хуульд заасан хугацаанд оршин суух зөвшөөрөл аваагүй "[redacted]" ХХК-д хөдөлмөр эрхлэгч ОХУ-ын 3 иргэний зөрчлийг хяналтын улсын байцаагч С.Гүлбанууд шилжүүлсэн. Паспорт, бичиг баримтаа биедээ авч яваагүй "[redacted]" ХХК-д хөдөлмөр | | |

59

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | эрхлэгч БНСВьетнам Улсын 1 иргэний зөрчлийг хяналтын улсын байцаагч С.Алтаннурт шилжүүлсэн.<br>Тайлант хугацаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдээгүй.<br>Тайлант хугацаанд 2 орны 4 гадаадын иргэн, 1 аж ахуйн нэгж, байгууллагын 3 нийт 7 зөрчлийг шалган шийдвэрлэсэн. Үүнд:<br>-Хуульд заасан хугацаанд оршин суух зөвшөөрөл аваагүй ‘[illegible]” ХХК /БНУзбекистан Улсын 2 иргэн/-ийг Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.1-д заасны дагуу нийт 1.800.000 төгрөгөөр,<br>-Гадаадын иргэний визийн байх хугацааг хэтрүүлсэн ‘[illegible]” ХХК /БНУзбекистан Улсын 1 иргэн/-ийг Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.3-д заасны дагуу 330.000 төгрөгөөр,<br>-Монгол Улсад байх визийн хугацааг 2 хоног хэтрүүлсэн БНКазахстан Улсын 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг үндэслэн 20.000 төгрөгөөр,<br>-Оршин суух хугацааг 3 хоног хэтрүүлсэн БНКазахстан Улсын 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.2-д заасны дагуу 30.000 төгрөгөөр,<br>-БНУзбекистан Улсын 1 иргэний визийн хугацааг 25 хоног хэтрүүлсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3-д заасны дагуу 250.000 төгрөгөөр, мөн иргэний ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасны дагуу 100.000 төгрөгөөр тус тус торгосон. | | |

60

| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Арга хэмжээ 2.2. Харьяалах нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт хяналт тавих | Хяналт тавьсан ажлын гүйцэтгэл | - | 50 | Тус аймагт үйл ажиллагаа явуулдаг “[redacted]”-ын үйл ажиллагаанд 2024 оны 3 дугаар сард төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, гадаадын иргэдийн бичиг баримт, оршин суух үнэмлэхийн хугацаа, зөвшөөрөлтэй хөдөлмөр эрхэлж байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан. Тус байгууллага, гадаадын иргэний бичиг баримттай холбоотой зөрчил илрээгүй. | 1-6 | 100 |
| 6. | Арга хэмжээ 2.3. Гадаадын иргэний хяналтыг сайжруулж, хууль зөрчсөн гадаадын иргэнд хориг арга хэмжээ авч хэрэгжүүлэх | Хууль зөрчсөн гадаадын иргэнд авсан хориг арга хэмжээний хувь | 100 | 50 | Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэн 2. Үүнд:<br>-Оршин суух зөвшөөрлийн хугацаа дууссан боловч Монгол Улсаас гарч явахаас зайлсхийсэн БНУзбекистан Улсын 2 иргэний талаар илтгэх хуудас, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр төвд танилцуулж, байгууллагын даргын шийдвэрээр Цагааннуур боомтоор албадан гаргасан.<br>Сонсох ажиллагаа явуулсан 5. Үүнд:<br>-Монгол Улсаас албадан гаргах БНУзбекистан Улсын 2 иргэн, БНКазахстан Улсын 3 иргэнд сонсох ажиллагаа явуулж, БНУзбекистан Улсын 2 иргэн, БНКазахстан Улсын 1 иргэний хурууны хээг авч төвд дотоод сүлжээгээр хүргүүлсэн.<br>Тайлант хугацаанд Цагааннуур авто замын шалган нэвтрүүлэх боомтод 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 03 дугаар сарын 06-ний өдрийг дуустал, 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрийг дуустал үүрэг гүйцэтгэж, гадаадын иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан. | 1-6 | 100 |

| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хил нэвтрүүлэлгүй буцаасан гадаадын иргэн 2.<br>Үүнд:<br>-Монгол Улсаас албадан гаргагдсан бөгөөд Монгол Улсад орохыг хориглосон хугацаа дуусаагүй ОХУ-ын 1, БНКазахстан Улсын 1 иргэнтэй ярилцлага хийж, Хил хамгаалах байгууллагатай хамтран улсын хил нэвтрүүлэлгүй буцаасан.<br>Цагааннуур авто замын боомтоор зорчиж буй БНЭнэтхэг Улсын 1 иргэн, ОХУ-ын 12 иргэн, Нидерландын Вант Улсын 1 иргэн, БНКазахстан Улсын 2, БНУзбекистан Улсын 1 иргэнтэй ярилцлага хийсэн.<br>2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Цагааннуур боомтод ХБНГУ-аас Улаанбаатар чиглэлд нислэг үйлдэж буй нисдэг тэргээр ирсэн Канад Улсын 1 иргэний паспорт, бичиг баримтыг шалгасан.<br>2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Цагааннуур боомтод ХБНГУ-аас Улаанбаатар чиглэлд нислэг үйлдэж буй нисдэг тэргээр ирсэн БНФранц Улсын 1, ИБУИНВУ-ын 1 иргэний паспорт, бичиг баримтыг шалгасан. | | |
| Зорилт 3. “МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ БОЛОХ, ХАРЬЯАТААС ГАРАХ, ИРГЭНИЙ ХАРЬЯАЛЛАА СЭРГЭЭН ТОГТООЛГОХ ХҮСЭЛТ ГАРГАСАН ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАЛАЛГҮЙ ХҮНИЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ САНГ БҮРДҮҮЛЖ, БАЯЖИЛТ ХИЙХ” | | | | | | | |
| 7. | Арга хэмжээ 3.1.<br>Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах хүсэлт гаргагчийн өргөдөл хүсэлт, холбогдох материалын бүрдлийг хангуулан хянаж, арга | Зохион байгуулалтын ажлын хувь | 100 | 50 | Монгол Улсын харьяатаас гарах хүсэлтэй өрхийн иргэний материалын бүрдлийг хянасан. | 1-6 | 85 |

62

62

| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх | | | | | | |
| 8. | Арга хэмжээ 3.2. Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргагчийн өргөдөл хүсэлт, холбогдох материалын бүрдлийг хангуулан хянаж, арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх | Зохион байгуулалтын ажлын хувь | 100 | 50 | Монгол Улсын иргэний харьяалал сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан [redacted] өрхийн [redacted] иргэн, Монгол Улсын харьяат болох [redacted] өрхийн [redacted] иргэний өргөдөл материалын бүрдлийг хянаж төвд хүргүүлсэн.<br>Иргэний харьяалал сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй [redacted] хүний өргөдөл, анкетыг дахин бүрдүүлж төвд хүргүүлсэн. | 1-6 | 90 |
| 9. | Арга хэмжээ 3.3. Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийн бүртгэл, судалгаа хөтлөх, зөрчлийг шийдвэрлэх арга хэмжээ зохион байгуулах | Зохион байгуулалтын ажлын хувь | 100 | 50 | Тайлант хугацаанд Монгол Улсын харьяатаас гаралгүй БНКазахстан Улсын харьяат болж, хоёрдмол харьяалал үүсгэсэн нийт [redacted] зөрчлийг илрүүлж, бүртгэлжүүлсэн.<br>Хоёрдмол харьяаллын хасалт [redacted] Үүнд: Хоёрдмол харьяалалтай байсан БНКазахстан Улсын [redacted] иргэн БНКазахстан Улсын харьяатаас гарсан тул хасалт хийсэн.<br>Хоёрдмол харьяаллын чиглэлээр 2024 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулсан.<br>[redacted]<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн [redacted] дугээр сарын [redacted]-ны өдрийн [redacted] дугаар зарлигаар Монгол Улсын харьяатаас гарсан [redacted] хүний мэдээлэл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн [redacted] ны өдрийн [redacted] дугаар зарлигаар харьяатаас | 1-6 | 100 |

| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гарсан [redacted] хүний мэдээллийг мэдээллийн санд нэмж шинэчилж, хэлтсийн албан хаагчдад өгсөн.<br>БНКазахстан Улсын Ерөнхийлөгчийн [redacted] дугээр зарлигаар тус улсын харьяатаас гарсан [redacted] хүнтэй холбогдож дараах ажиллагааг хийсэн. Үүнд:<br>-Монгол Улсын иргэний харьялал сэргээн тогтоолгох материал өгсөн [redacted] өрхийн [redacted] хүн,<br>-Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан [redacted] өрхийн [redacted] хүн,<br>-Хоёрдмол харьяалалтай байсан [redacted] хүнийг хоёрдмол харьяалалтай иргэдийн бүртгэлээс хассан. | | |
| Зорилт 4. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” | | | | | | | |
| Зорилт 1: Олон талт хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадварыг бэхжүүлнэ. (Гадаадын иргэн, харьятын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 4, 5, 6 дугаар зорилт) | | | | | | | |
| 10. | Арга хэмжээ 4.1.<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний холбогдох заалтын хэрэгжилтийг хангах | Төлөвлөгөөний холбогдох заалтын хэрэгжилтийн хувь | 80 | 50 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний холбогдох заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хэлтсийн албан хаагчдад “Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын хор хөнөөлийн талаар” дотоод сургалт орсон. | 1-6 | 95 |
| 11. | Арга хэмжээ 4.2.<br>Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх | Шийдвэрлэлтийн хувь | 100 | 50 | Иргэдээс гаргасан 6 өргөдлийг хүлээн авч, бүрдлийг хангуулан бичиг хэрэгт шилжүүлсэн.<br>Иргэний харьяаллын чиглэлээр 11 иргэнд лавлагаа олгосон. | 1-6 | 100 |
| 12. | Арга хэмжээ 4.3. | Үүсгэсэн архивын | 2 | 3-аас | Хэлтсийн 2023 оны үйл ажиллагааны дунд | 1-6 | 100 |

64

| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангаж ажиллах | баримтын тоо | | доошгуй | үүссэн баримт бичгүүдийг цэгцэлж нийт 10 архивын нэгж бүрдүүлж, бүртгэлийн 3 дэвтрийг дугаарлаж архивт баримтаар хүлээлгэн өгсөн. Үүнд:<br>- Зөрчил шалган шийдвэрлэсэн материал 6 архивын нэгж,<br>- Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийн материал 2 архивын нэгж,<br>Хоёрдмол харьяалалтай иргэдээс хасалт хийсэн материал 1 архивын нэгж,<br>- Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны материал 1 архивын нэгж,<br>- Харьяатын материал хянасан бүртгэлийн дэвтэр 1, харьяалалгүй хүний бүртгэлийн дэвтэр 1, хоёрдмол харьяалалтай иргэдээс хасалт хийсэн бүртгэлийн дэвтэр 1.<br>Ирсэн бичиг 29 хүлээн авсан.<br>Явсан бичиг 22 боловсруулсан.<br>Илтгэх хуудас 10 үйлдэж, холбогдох нэгжид хүргүүлсэн. Үүнд:<br>- Хилийн боомтод цахим визтэй холбоотой тулгарч буй хүндрэлийн талаар байгууллагын даргад,<br>- Хэлтсийн төвийн албаны байрны талаар байгууллагын даргад,<br>- Хариуцлагатай жижүүрээр ажилласан талаар ЗУГ-т,<br>- Гадаадад зорчсон албан хаагчдын талаар ЗУГ-т,<br>- Албаны автотээврийн хэрэгслийн улсын дугаар солисон талаар ЗУГ-т,<br>- БНКазахстан Улсын 1 иргэний талаар | | |

| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - ЗШШГ-т,<br>- Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах талаар ЗШШГ-т,<br>- Галын хор, галын аюулаас хамгаалах хэрэгслийн зардал шийдвэрлүүлэх талаар хэлтсийн даргад,<br>Дотоод сургалт зохион байгуулсан талаар хэлтсийн даргад 2 удаа тус тус илтгэх хуудас илгээсэн.<br>Дотоод албан бичиг 5 хүргүүлсэн. | | |
| 13. | Арга хэмжээ 4.4. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох | Оролцсон арга хэмжээний тоо | - | 3-аас доошгүй | Ажлын газрын шинэ жилийн арга хэмжээнд оролцож, нээлтэд нь морин хуур тоглосон.<br>Наурызын баярын жагсаалд хэлтсийн албан хаагчдын хамт оролцсон.<br>Хамт олны дунд эерэг уур амьсгал бүрдүүлэх, албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор долоо хоногт 3 цаг биеийн тамирын зааланд хичээллэх зорилтын хүрээнд мягмар гараг бүр 2 цаг биеийн тамирын зааланд хичээллэж хэвшсэн. Мөн өглөө бүр тогтмол 15 минут тогтмол дасгал хийж хэвшсэн. | 1-6 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Боомтын өдөр тутмын нөхцөл байдлын мэдээг тухай бүр цахимаар төвд хүргүүлэх | Илгээсэн мэдээний тоо | 133 | Цагааннуур, Даян боомтын өдөр тутмын нөхцөл байдлын мэдээг тухай бүр төвд хүргүүлсэн байна. | Цагааннуур, Даян боомтын өдөр тутмын нөхцөл байдлын мэдээг нийт 117 удаа цахимаар төвд хүргүүлсэн. | 1-6 сар | 100 |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Хэлтсийн үйл | Нэгтгэсэн мэдээний тоо | 41 | Хэлтсийн төвийн болон Цагааннуур | Хэлтсийн төвийн болон Цагааннуур боомтын өдөр тутмын нөхцөл | 1-5 сар | 100 |

| | | | | | | | |
